



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/89

Хэрлэн сум


Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Жимобайл" ХХК-аас Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн ЦХХХЯ/20240101004 дугаар тендер сонгон шалгаруулалтыг явуулахыг даалгасан аймгийн Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгуулах талаар нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.4, 28.2.5, 28.2.6 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Г.Лхагвахатан)-д олгож, аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож хэргийн шийдвэрлэлтийн талаар тухай бүр танилцуулахыг итгэмжлэгдсэн төлөөлөгчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ДАЮУРБУНЬ



قصص

٦٥ ٥٥ ٦٥
 بقدر منكم بقدر

